



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/216

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.16, 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 24 дүгээр зүйлийн 24.1.5, 25 дугаар зүйлийн 25.1.7, 25.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургуулийг Ховд аймгийн Онцгой байдлын газрыг түшиглэн 2016 оны 09 дүгээр сарын 26-аас 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтад оролцох албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дадлага сургуулийг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг Ховд аймгийн Онцгой байдлын газар (Онцгой байдлын дэд хурандаа С.Өлзийхишиг)-т үүрэг болгосугай.

4. Сургалтад оролцох албан хаагчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчлагааг өгч, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Ховд аймгийн Онцгой байдлын газрын сургагч багш, Монгол Улсын гавьяат тамирчин, уулын спортын мастер Т.Гүррагчаад даалгасугай.

5. Сургалтад хамрагдах албан хаагчдын байр, хоол, унааны зардлыг гаргахыг Ховд аймгийн Онцгой байдлын газар (онцгой байдлын дэд хурандаа С.Өлзийхишиг), Увс аймгийн Онцгой байдлын газар (онцгой байдлын хурандаа Б.Баттулга), Завхан аймгийн Онцгой байдлын газар (онцгой байдлын хурандаа Ө.Болд), Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар (онцгой байдлын дэд хурандаа С.Пүрэвсамдан)-т тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

007625

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016  
оны 27 дугаар сарын 24 ны өдрийн 27 дугаар  
тушаалын хавсралт 36/16

Баруун бүсэд зохион байгуулагдах "Өндөр уулнаас эрэн хайх, аврах  
ажиллагаа" сэдэвт дадлага сургуульд оролцогчдын нэрс

№	Байгууллага	Албан хаагчийн нэр	Цол	Албан тушаал
1	Ховд аймгийн Онцгой байдлын газар	С.Мөнхбат	ахлагч	Аврагч
2		Ц.Нямбаяр	ахлагч	Аврагч
3		Б.Амармэнд	ахлагч	Аврагч-гал сөнөөгч
4	Увс аймгийн Онцгой байдлын газар	Д.Түвшинжаргал	дэслэгч	Эрэн хайх аврах бүлгийн дарга
5		Н.Даваа	Ахлах ахлагч	Аврагч
6		Ц.Чинзориг	ахлагч	аврагч
7	Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар	Т.Бэргэн	Ахлах ахлагч	Аврагч-жолооч
8		А.Бержан	Ахлах ахлагч	Гал сөнөөгч
9		А.Билгүүнбаяр	Ахлах ахлагч	Усчин-аврагч
10		А.Асамбек	Ахлах ахлагч	Аврагч-гал сөнөөгч
11	Завхан аймгийн Онцгой байдлын газар	Г.Маналжав	ахлагч	Аврагч-гал сөнөөгч
12		М.Эрдэнэменх	ахлагч	Аврагч-гал сөнөөгч

---oO---

БАТЛАВ  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Т. БАДРАЛ

2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр

**АРХАНГАЙ, БАЯН-ӨЛГИЙ, ГОВЬ-АЛТАЙ, ЗАВХАН, УВС, ХОВД  
АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРУУДЫН ХАМТАРСАН ХЭЭРИЙН  
ДАДЛАГА СУРГУУЛИЙН УДИРДАМЖ**

**Нэг: Дадлага сургуулийн зорилго:**

Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, тэсвэр хатуужил, багаар хамтран ажиллах, албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэхэд гол зорилго оршино.

**Хоёр: Дадлага явуулах хугацаа:**

Тус хамтарсан дадлага сургуулийг Увс аймгийн Завхан сумын Хяргас нуурын "Хэцүү хад" жуучны баазад 2016 оны 9 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулж явуулна.

**Гурав: Дадлагад оролцох бүрэлдэхүүн:**

3.1. Дадлага сургуульд Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай, Архангай аймгийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн оролцоно.

3.2. Оролцох бүрэлдэхүүний тоог тухайн газрууд өөрсдөө тогтооно.

**Дөрөв: Дадлагын төрөл:**

1. Онцгой байдлын газруудын офицер бүрэлдэхүүний дунд штаб тактикийн дадлага сургууль зохион байгуулах. /Дадлага, туршлага солилцох./

2. Марш тактикийн бэлтгэлжилт

3. Уснаас эрэн хайх аврах ажиллагаа

4. Өндөр уулнаас нэрвэгсдийг буулгах, аврах ажиллагаа явуулах

5. Ой хээрийн болон объектын гал түймрийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулах /дадлага, туршлага солилцох/

**Тав: Дадлага хийх аргачлал:**

5.1. Онцгой байдлын газруудын офицер бүрэлдэхүүнд 2 төрлийн цагийн байдалд хүч хэрэгслийг зөв зохион байгуулах, байр зүйн зурагт оруулах дадлага хийнэ. /Цагийн байдал дээр ажиллах бичгийн хэрэгсэл, бусад зүйлсийг өөрсдөө бэлтгэж ирэх./

5.2. Марш тактикийн бэлтгэлжилтээр тасаг тус бүр 10 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй хээрийн хувцас, хагас түрийтэй гуталтай, 3 цэгт үүрэг гүйцэтгэнэ. Нийт 10 км-ийн марш үйлдэж 3 цэгт тактик хийнэ.

1 дүгээр цэг: Гараанаас гарч 1.5 км гүйгээд гар дээр 30 суниах

2 дугаар цэг: 3 км гүйгээд гэдэсний таталт 30 хийх

3 дугаар цэг: 5 км гүйгээд тодорхой орон зайд өгөгдсөн 3 цэгийг байршил тогтоогоор олж 3 дугаар цэг дээрээс станцын солбилцол авч станцад оруулж цагийн байдлыг өгч дараагийн цэг рүү явна.

4 дүгээр цэг: 7.5 км гүйгээд тусгайлсан бэлтгэсэн газрын зураг дээр цагийн байдлын дагуу тэмдэг тэмдэглэгээ оруулж 2,5 км гүйгээд барианд орно.

5.3. Уснаас эрэн хайх аврах ажиллагааг Хяргас нууранд 9 метр гүний шумбалт хийж осолдсон хүнийг эрэн хайж гаргах. Гүний шумбалтын иж бүрэн хувцас хэрэгсэл, нөөц баллон, баллон цэнэглэгч зэрэг байна. Шумбалт хийх үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулсан байх.

5.4. 3-8 метр эгц уул руу авирх, 2 нэрвэгдсэн иргэнийг буулгах ажлыг зохион байгуулах.

**Зургаа: Нөхөрсөг хөл бөмбөгийн тэмцээн явуулах :**

Дээрх 6 аймгийн Онцгой байдлын газар тус бүр албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр нөхөрсөг тэмцээн уралдааныг зохион байгуулна. Тухайн тэмцээн уралдааны удирдамжийг боловсруулж, шагнал урамшуулыг урьдчилан бэлтгэж ирэх. Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнүүд биеийн тамирын хувцастай байна.


**Долоо: Бусад**

Тухайн хамтарсан дадлага сургуульд оролцох Онцгой байдлын газрууд байрлах майхан, хөнжил, хоол хүнс, шатахууны зардлаа өөрсдөө хариуцана.

Албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг чанд сахиж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж оролцох.

ХЯНАСАН:  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА  
ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ХУРАНДАА  Б.БАТТУЛГА



УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:  
ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ, БЭЛЭН  
БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ХОШУУЧ  П.УУГАНБАЯР